



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/131

Шивээговь сум

“Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ” хийх комисс томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2021 оны А/147 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Шивээговь суманд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Комиссын дарга: Ч.Сугармаа /сумын Засаг даргын орлогч/
- Нарийн бичгийн дарга: Д.Сувд-Эрдэнэ /Нийгмийн бодлогын мэргэжилтэн
- Гишүүд: Д.Отгонжаргал /ЗДТГ-ын дарга/
У.Энх-Амгалан /Санхүү албаны дарга/
О.Болормаа /Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн/
Д.Отгонбаатар /Хүнс, жижиг дунд, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн/-ний үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Ууганбаяр /Архив, бичиг хэргийн эрхлэгч/

2. “Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ” хийх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. “Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ”-г хугацаанд нь чанартай хийж дүгнэлт, зөвлөмжийг танилцуулахыг комиссын дарга /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ